



АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/129

Улаанбаатар хот

"Аймгийн Автотээврийн төв"-ийн нийтлэг
дүрмийн зарим заалтанд өөрчлөлт
оруулах тухай

Иргэний хуулийн 29 дүгээр зүйл, Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Төрийн өмчийн хорооны 2015 оны 174 дугаар тогтоолоор батлагдсан "Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 6.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Автотээврийн Үндэсний Төв" ТӨҮГ-ын захирлын 2015 оны 0 6 дугаар сарын 24-ний өдрийн А/115 дугаар тушаалаар батлагдсан "Аймгийн Автотээврийн төв"-ийн нийтлэг дүрмийн 4.2-т "Төвийн дарга, менежер, техникийн хяналтын инженер, ахлах няглан бодогчийг Үйлдвэрийн газрын захирал томилж, чөлөөлнө" гэснийг "Төвийн ажилтнуудыг Үйлдвэрийн газрын захирал томилж чөлөөлнө" гэж

4.3.1-т "Төвийн батлагдсан бүтэц, орон тоонд тохируулан энэ журмын 4.2-т зааснаас бусад ажлын байранд хүний нөөцийг судалж, томилж, чөлөөлөх" гэснийг "Төвийн батлагдсан бүтэц орон тоонд тохируулан хүний нөөцийг судалж, саналаа Үйлдвэрийн захиралд хүргүүлэх" гэж

4.3.2-т "Төвийн ажилтнуудад Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журамд заасан сахилгын шийтгэл ногдуулах" гэснийг "Төвийн ажилтнуудад Хөдөлмөрийн тухай хууль, тогтоомж, байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах хүсэлтээ (зөрчлийг шалган тогтоож) үйлдвэрийн захиралд ирүүлэх" гэж

4.3.4-т "Энэхүү журмын 4.3.1-т зааснаар томилогдсон ажилтнуудтай Хөдөлмөрийн гэрээ байгуулж, гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллах" гэснийг "Энэхүү журмын 4.2-т зааснаар томилогдсон ажилтнуудтай байгуулсан Хөдөлмөрийн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллах" гэж тус тус өөрчилсүгэй.

2. "Аймгийн Автотээврийн төв"-ийн нийтлэг дүрэмд орсон өөрчлөлтийг 2016 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Аймгийн Автотээврийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Дүрэм, тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Р.Отгонбаатар/-т даалгасугай.

ЗАХИРАЛ

Н.ПУНЦАГ



АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2015 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/213

Улаанбаатар хот

"Аймгийн автотээврийн төв"-ийн нийтлэг дүрэм -д
өөрчлөлт оруулах тухай

Иргэний хуулийн 29 дүгээр зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалт, Төрийн өмчийн хорооны 2015 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 174 дүгээр тогтоолоор батлагдсан "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын дүрмийн 6.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Аймгийн автотээврийн төв"-ийн нийтлэг дүрмийн дараах заалтуудыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

4.2. Төвийн дарга, менежер, техникийн хяналтын үзлэгийн инженер, ахлах нягтлан бодогчийг Үйлдвэрийн газрын захирал томилж, чөлөөлнө.

4.3.1. Төвийн батлагдсан бүтэц, орон тоонд тохируулан энэ журмын 4.2-т зааснаас бусад ажлын байранд хүний нөөцийг судлаж, томилох, чөлөөлөх;

2. "Аймгийн автотээврийн төв"-ийн нийтлэг дүрэмд орсон өөрчлөлтийг хэрэгжүүлж ажиллахыг Аймгийн Автотээврийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /М.Мөнхбаяр/-т даалгасугай.

ЗАХИРАЛ



Н.ПУНЦАГ



АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2015 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/115

Улаанбаатар хот

"Аймгийн автотээврийн төв"-ийн
нийтлэг дүрэм батлах тухай

Иргэний хуулийн 29 дүгээр зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалт, Төрийн өмчийн хорооны 2015 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 174 дүгээр тогтоолоор батлагдсан "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын дүрмийн 6.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Аймгийн автотээврийн төв"-ийн нийтлэг дүрэм"-ийг хавсралтаар баталсугай.
2. Шинээр батласан "Аймгийн автотээврийн төв"-ийн нийтлэг дүрэм"-ийг хэрэгжүүлж ажиллахыг Автотээврийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.
3. Дүрмийн хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /М.Мөнхбаяр/-т даалгасугай.
4. Энэхүү тушаалыг 2015 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.
5. Тушаал гарсантай холбогдуулан "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын захирлын 2013 оны 235 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ЗАХИРАЛ  НИПУНЦАГ



"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын
Захирлын 2015 оны 06 сарын 11-ны өдрийн
А... Тoot тушаалын хавсралт



"АЙМГИЙН АВТОТЭЭВРИЙН ТӨВ"-ИЙН НИЙТЛЭГ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Аймгийн автотээврийн төв нь орон нутаг дахь автотээврийн салбарын мэргэжлийн байгууллага мөн.

1.2.Энэхүү дүрмийн зорилго нь "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ/ цаашид Үйлдвэрийн газар гэх /-ын Аймгийн автотээврийн төвийн үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.3."Аймгийн автотээврийн төв" нь Монгол Улсын олон улсын холбогдох гэрээ, "Автотээврийн тухай хууль", "Иргэний хууль", "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль", "Хөдөлмөрийн тухай хууль" Үйлдвэрийн газрын дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

1.4."Аймгийн автотээврийн төв" нь хуулийн этгээдийн эрхгүй байна.

1.5."Аймгийн автотээврийн төв"-ийн / цаашид "төв" гэх / бүтэц зохион байгуулалт, орон тоо, цалин, урамшууллыг Үйлдвэрийн газрын захирал тогтооно.

Хоёр. Төвийн үйл ажиллагааны чиглэл

2.1.Аймгийн автотээврийн төв нь "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын дүрмийн 4.1-д заасан чиглэлээр харъяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаагаа эрхлэн явуулна.

Гурав. Төвийн эрх, үүрэг

3.1.Төв нь дор дурдсан эрх, үүрэгтэй байна. Үүнд:

3.1.1.Монгол Улсын хууль тогтоомж, Үйлдвэрийн газрын дүрэм болон энэхүү дүрэмд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулах;

3.1.2.Ажил, үйлчилгээний орлогыг үйлдвэрийн газарт бүрэн төвлөрүүлэх, үйлдвэрийн газраас олгосон санхүүжилтийг батлагдсан хуваарь, зориулалтын дагуу зарцуулах,

3.1.3.Үйл ажиллагааны зорилтот түвшинг бүрэн хэрэгжүүлэхэд чиглэсэн маркетинг, менежментийн үр ашигтай, оновчтой бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

3.1.4.Төвийн үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах;

3.1.5.Өөрийн эзэмшилд буй үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааны зорилгод нийцүүлэн ашиглах.

Дөрөв. Төвийн удирдлага түүний эрх, үүрэг

4.1.Төвийн өдөр тутмын үйл ажиллагааг Аймгийн автотээврийн төвийн дарга удирдан зохион байгуулна.

4.2.Төвийн даргыг Үйлдвэрийн газрын захирал томилж, чөлөөлнө.

4.3.Төвийн дарга дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.3.1.Төвийн батлагдсан бүтэц, орон тоонд тохируулан хүний нөөцийг судлаж, Үйлдвэрийн газрын захиралд танилцуулан бичгээр зөвшөөрөл авсаны үндсэн дээр томилж, чөлөөлөх;

4.3.2.Төвийн ажилтнуудад Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журамд заасан сахилгын шийтгэл ногдуулах;

4.3.3.Иргэн, хуулийн этгээдтэй аймгийнхаа нутаг дэвсгэрийн хүрээнд үйлчлэх аливаа гэрээг Үйлдвэрийн газарт танилцуулж зөвшөөрөл авсаны үндсэн дээр гэрээ байгуулах;

4.3.4.Энэхүү журмын 4.3.1. зааснаар томилогдсон ажилтануудтай Хөдөлмөрийн гэрээг байгуулж, гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллах;

4.3.5.Төвийн дарга нь өөрийн гаргасан тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах;

4.3.6.Үйл ажиллагааны зорилтот түвшинг бүрэн хэрэгжүүлэхэд чиглэсэн маркетинг, менежментийн оновчтой, үр ашигтай үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг хэрэгжүүлэх;

4.3.7.Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг төвд мөрдүүлэх, хүний нөөцийн мэдээ судалгааг тогтоосон хугацаанд үнэн зөв гаргаж хүргүүлэх;

4.3.8.Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, төвийн хэвийн үйл ажиллагааг хангасны үндсэн дээр санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг бүх талаар дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;

4.3.9.Нийтийн эрх ашгийг дээдэлж, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан ажиллаж, Төвийн харъяалах нутаг дэвсгэрийн хүрээнд үйлчилэх аливаа гэрээний хэрэгжилтэнд хяналт тавиж ажиллах;

4.3.10.Төвийн үйл ажиллагаатай холбоотой санхүү, мөнгөн хөрөнгө, эд хөрөнгө худалдан авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх зэрэг үндсэн болон хөдлөх эд

хөрөнгөтэй холбоотой аливаа асуудлаар Үйлдвэрийн газарт санал боловсруулж хүргүүлэх;

4.3.11.Төвийн ажилтнуудын цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийн асуудлаар Үйлдвэрийн газрын захиралд санал боловсруулж хүргүүлэх;

4.3.12.Төвийн дарга нь үйлдвэрийн газрын бусад этгээдтэй байгуулсан гэрээний үйлчлэлд харъяалах нутаг дэвсгэрийн хүрээнд хяналт тавьж, гэрээ зөрчсөнөөс үүсэх хариуцлагыг хүлээх;

4.3.13.Төвийн дарга нь өөрийн гаргасан тушаал, шийдвэрийн улмаас Үйлдвэрийн газарт болон бусдад учруулсан аливаа хохирол, төлбөр, үр дагварыг бүрэн хариуцах;

4.4.Төвийн дарга нь өөрт олгогдсон эрхийн хүрээнд тушаал гаргана;

4.5.Энэхүү дүрмээр зөвшөөрөөгүй аливаа асуудлаар тушаал гаргахыг хориглоно;

4.6.Үйлдвэрийн газрын захирал нь Төвийн даргын хууль, дүрэм, журамд нийцээгүй тушаал шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох эрхтэй.

Тав. Төвийн санхүүжилт, санхүү, бүртгэл

5.1.Төвийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

5.1.1.Үйлдвэрийн газрын санхүүжилт;

5.1.2.Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй Төвийн санаачилгаар бий болсон шинэ бүтээгдэхүүн, ажил үйлчилгээнээс олсон орлого болон бусад нэмэлт орлогын Төвд ноогдох хэсэг;

5.1.3 Хууль тогтоомжоор хориглоогүй бусад үйл ажиллагааны орлого;

5.2.Төв нь арилжааны банкинд харилцах данстай байна.

5.3.Төв нь санхүүгийн тайлан бүртгэлийг Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, бусад холбогдох хуулийн дагуу хөтөлж явуулна.

5.4.Төвийн санхүүгийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, мөн оны 12 дугаар сарын 31-нд дуусгавар болно. Жил бүрийн орлого, зарлагын төсвийн санал, гүйцэтгэлийг тогтоосон хугацаанд Үйлдвэрийн газарт хүргүүлнэ.

5.5.Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн мэдээ, тайлангийн үнэн зөвийг Төвийн дарга, нягтлан бодогч нар хариуцна.

Зургаа. Төвийг шинээр байгуулах, өөрчлөх, татан буулгах

6.1. Иргэний хууль болон бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр Төвийг шинээр болон өөрчлөн байгуулж, татан буулгана.

6.2. Хуульд заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр Төвийг өөрчлөн байгуулах, татан буулгахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд Төв нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.

Долоо. Дотоод хяналт, аудит

7.1. Төвийн дотоод хяналт шалгалт, дотоод аудитыг Үйлдвэрийн газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь холбогдох хууль, дүрэм, журмын дагуу хэрэгжүүлнэ.

7.2. Төв нь Үйлдвэрийн газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэсээс авч хэрэгжүүлсэн шалгалтын дүнг үндэслэж өгсөн үүрэг, даалгавар, зөвлөмжийн хариуг Үйлдвэрийн газрын захирал болон Тамгын газарт хүргүүлнэ.

7.3. Төрийн өмчийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг Төвийн нягтлан бодогч хариуцна.

Найм. Бусад

8.1. Энэхүү дүрэм, Үйлдвэрийн газрын дүрэмд тусгагдсанаас бусад асуудлыг хуулиар зохицуулна.

8.2. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл Үйлдвэрийн газрын Захирлын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

----- о о о -----